



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/138/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТНГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор С.Намшир

Утас: 70273465 Цахим хаяг: namshirs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.08.25 № 01/137
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.ГАНТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд 14 төрийн албан хаагчдад цалингийн хэмнэсэн зардлаас 11,013.8 төгрөгийн урамшуулал, 2 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5 жилийн мөнгөн урамшуулал олгохдоо 1,608.2 төгрөгийн ХХОАТ суутгаагүй, татварын байгууллагад 8,954.4 төгрөгийн авлагатай, буруу эдийн засгийн ангиллаас 5,034.6 мянган төгрөгийн гүйлгээ гаргасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах

412505328

орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс

дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Тус байгууллага нь 2024 онд Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 7 зорилт 107 арга хэмжээтэй 94,0%, сумын 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 83,0%, урианы жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 85,0%-тай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газар нь улс, аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ланд 76 автомашиныг 149.0 сая төгрөг, халуун усны шинэ байрыг 199.6 сая төгрөг, төмсний комбайныг 197.0 сая төгрөг, хүнсний ногооны үрлэгчийг 32.1 сая төгрөг, хадуурыг 79.5 сая төгрөгөөр тус тус хүлээн авч, хөрөнгийн дансанд бүртгэж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сумын ИТХ-аас 2024 оныг “Залуучуудын манлайлал, гэр бүлийн хөгжил”-ийг дэмжих урианы жил болгон зарласан байна. Урианы жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 85,0 хувиар биелүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>224,543,222.86</u>	<u>53,888,813.90</u>
33	АВЛАГА	170,325,546.46	1,856,700.00
335	Бусад авлага	170,007,697.00	1,856,700.00
3351	Байгууллагаас авах авлага	164,375,997.00	300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,631,700.00	1,556,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,217,676.40	52,032,113.90
351	Түүхий эд материал	43,323,866.40	38,231,106.40
35110	Тусгай зориулалттай материал	43,323,866.40	38,231,106.40
354	Хангамжийн материал	5,893,810.00	8,801,007.50
35410	Бичиг хэргийн материал	1,655,620.00	1,495,490.00
35420	Аж ахуйн материал	550,000.00	1,007,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,615,000.00	3,067,739.00
35440	Түлш, шатах тослох материал	73,190.00	134,378.50
35450	Барилгын засварын материал	00.00	3,095,600.00
35600	Мал амьтад	5,000,000.00	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,274,355,580.66</u>	<u>2,255,062,701.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,274,355,580.66	2,255,062,701.67
392	Биет хөрөнгө	1,259,927,580.66	2,112,986,701.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,024,153,004.66	1,363,997,519.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-366,892,951.14	-390,368,342.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	175,838,611.00	633,465,361.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124,265,062.05	-146,996,577.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	400,085,293.00	407,599,754.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,402,274.46	-171,693,385.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,557,250.00	94,007,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,892,391.43	-49,986,109.40
39209	Зам, гүүрийн байгууламж	768,255,100.00	768,255,100.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-758,255,100.00	-758,255,100.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	285,278,404.00	477,742,379.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-106,541,302.92	-124,781,147.88
393	Биет бус хөрөнгө	14,428,000.00	142,076,000.00
39301	Програм хангамж	1,645,000.00	8,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165,000.00	-165,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,948,000.00	133,596,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,498,898,803.52</u>	<u>2,308,951,515.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>2,157,873.39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,157,873.39
413	Өглөг	00.00	2,157,873.39

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,157,873.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,498,898,803.52	2,306,793,642.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,498,898,803.52	2,306,793,642.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	575,954,182.52	575,954,182.52
51101	Өмч: - төрийн	575,954,182.52	575,954,182.52
512	Хуримтлагдсан үр дүн	717,466,547.64	1,534,648,186.90
51210	Өмнөх үеийн үр дүн	717,466,547.64	726,753,348.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	807,894,838.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,478,073.36	196,191,272.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,498,898,803.52	2,308,951,515.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	993,464,261.51	1,999,770,490.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,688,189.51	870,752,225.13
120	Нийтлэг татварын бус орлого	226,688,189.51	870,752,225.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	226,688,189.51	870,752,225.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	226,688,189.51	870,752,225.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	766,776,072.00	1,129,018,265.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,945,272.00	239,543,765.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,945,272.00	239,543,765.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	680,830,800.00	889,474,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	680,830,800.00	889,474,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	667,764,383.47	1,073,119,100.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,764,383.47	1,073,119,100.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	658,115,297.16	934,977,919.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,852,336.89	560,669,050.60
210101	Үндсэн цалин	294,572,429.18	291,113,189.39
210102	Нэмэгдэл	60,279,907.71	252,855,461.21
210104	Урамшуулал	00.00	16,700,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,352,145.69	66,818,624.23
210201	Тэтгэврийн даатгал	29,249,323.72	45,098,805.44
210202	Тэтгэмжийн даатгал	6,567,022.44	5,133,822.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,375.08	3,036,931.51
210204	Ажилгүйдлийн даатгал	729,299.35	2,733,621.11

210205	Эрүүл мэндийн даатгал	5,512,125.10	10,815,444.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,629,011.06	48,066,099.57
210301	Гэрэл, цахилгаан	3,375,242.06	8,041,938.57
210302	Түлш, халаалт	38,253,769.00	40,024,161.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,903,825.00	52,555,812.70
210401	Бичиг хэрэг	1,255,900.00	2,802,493.00
210402	Тээвэр, шатахуун	17,200,925.00	47,577,219.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,447,000.00	2,176,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	14,660,600.00
210604	Урсгал засвар	00.00	14,660,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,805,700.00	7,670,000.00
210702	Дотоод албан томилолт	4,805,700.00	7,670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,690,000.00	15,899,872.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,000.00	14,436,824.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	311,048.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,532,278.52	168,637,860.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,274,450.00	58,655,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,257,828.52	109,982,500.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,649,086.31	138,141,180.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	105,300,963.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,608,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	79,611,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,081,663.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	836,430.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	836,430.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,649,086.31	32,003,786.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,649,086.31	32,003,786.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	325,699,878.04	926,651,389.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,738,000.68	118,756,551.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,738,000.68	118,756,551.09
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-11,738,000.68	-118,756,551.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	313,961,877.36	807,894,838.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	766,776,072.00	1,129,018,265.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	766,776,072.00	1,129,018,265.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,945,272.00	239,543,765.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,945,272.00	239,543,765.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	680,830,800.00	889,474,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	680,830,800.00	889,474,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	528,812,875.00	1,063,025,965.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,812,875.00	1,063,025,965.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	519,163,788.69	924,884,784.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,221,207.02	560,669,050.60
210101	Үндсэн цалин	294,891,111.73	291,113,189.39
210102	Нэмэгдэл	60,330,095.29	252,855,461.21
210104	Урамшуулал	00.00	16,700,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,801,025.61	64,642,901.38
210201	Тэтгэврийн даатгал	29,150,113.51	43,932,407.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,413,434.15	5,168,600.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,817,550.15	2,620,324.54
210204	Ажилгүйдлийн даатгал	679,900.56	2,584,477.66
210205	Эрүүл мэндийн даатгал	6,740,027.24	10,337,091.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,629,011.06	48,066,099.57
210301	Гэрэл, цахилгаан	3,118,668.28	8,041,938.57
210302	Түлш, халаалт	38,510,342.78	40,024,161.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,554,500.00	32,566,728.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,642,363.00
210402	Тээвэр, шатахуун	11,257,500.00	25,248,265.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,597,000.00	2,176,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,300,000.00	8,510,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	60,000.00
210604	Урсгал засвар	12,300,000.00	8,450,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,805,700.00	7,670,000.00
210702	Дотоод албан томилолт	4,805,700.00	7,670,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,605,695.00	29,672,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,435,695.00	28,220,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,246,650.00	173,087,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,246,650.00	173,087,975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,649,086.31	138,141,180.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	105,300,963.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,608,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	79,611,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,081,663.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	836,430.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	836,430.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,649,086.31	32,003,786.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,649,086.31	32,003,786.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	237,963,197.00	65,992,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	237,963,197.00	65,992,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	237,963,197.00	65,992,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	237,963,197.00	65,992,300.00
221001	Их засвар	164,375,997.00	28,322,300.00
222001	Тоног төхөөрөмж	13,587,200.00	6,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	31,370,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	237,963,197.00	-65,992,300.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	717,466,547.64	1,498,898,803.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	717,466,547.64	1,498,898,803.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	9,286,800.60	9,286,800.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	726,753,348.24	1,508,185,604.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-9,286,800.60	00.00	-9,286,800.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	807,894,838.66	807,894,838.66
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	196,191,272.76	1,534,648,186.90	2,306,793,642.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	926,508,200.00	811,348,413.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,508,200.00	811,348,413.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	837,288,900.00	722,129,113.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,694,300.00	510,251,337.52
210101	Үндсэн цалин	338,202,900.00	291,113,189.39
210102	Нэмэгдэл	206,791,000.00	202,437,748.13
210104	Урамшуулал	16,700,400.00	16,700,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,211,900.00	58,236,013.38
210201	Тэтгэврийн даатгал	47,744,000.00	39,575,769.22
210202	Тэтгэмжийн даатгал	5,617,000.00	4,656,049.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,808,500.00	2,364,021.54
210204	Ажилгүйдлийн даатгал	2,808,500.00	2,328,174.66

210205	Эрүүл мэндийн даатгал	11,233,900.00	9,311,998.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,802,500.00	48,066,099.57
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	8,041,938.57
210302	Түлш, халаалт	47,802,500.00	40,024,161.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,605,200.00	27,380,663.00
210401	Бичиг хэрэг	2,643,000.00	2,642,363.00
210402	Тээвэр, шатахуун	20,062,200.00	20,062,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,176,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,500,000.00	12,480,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,480,000.00
210604	Урсгал засвар	70,000,000.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,000,000.00	6,990,000.00
210702	Дотоод албан томилолт	7,000,000.00	6,990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,452,000.00	41,702,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.00	7,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22023000.00	17023000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,023,000.00	17,023,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89219300.00	89219300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,219,300.00	89,219,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.00	6,608,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,611,300.00	79,611,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,122,300.00	46,122,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,122,300.00	46,122,300.00
221001	Их засвар	39,822,300.00	39,822,300.00
222001	Тоног төхөөрөмж	6,300,000.00	6,300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	972,630,500.00	889,474,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	972,630,500.00	00.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	972,630,500.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	18
620001	Удирдах ажилтан	06	06
620002	Гүйцэтгэх ажилтан	09	05
620003	Үйлчлэх ажилтан	07	07

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,945,272.0	86,447,359.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,945,272.0	86,447,359.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,945,272.0	70,365,696.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,308,719.0	50,417,713.08
210102	Нэмэгдэл	22,308,719.0	50,417,713.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,788,608.0	6,406,888.00
210201	Тэтгэврийн даатгал	1,896,247.0	4,356,638.00
210202	Тэтгэмжийн даатгал	223,089.0	512,551.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	265,314.0	256,303.00
210204	Ажилгүйдлийн даатгал	44,621.0	256,303.00
210205	Эрүүл мэндийн даатгал	359,337.0	1,025,093.00
2104	Хангамж, бараа материалын зардал	230,000.0	5,186,065.00
210402	Тээвэр, шатахуун	230,000.0	5,186,065.00
2107	Томилолт, зочны зардал	-	680,000.00
210702	Дотоод албан томилолт		680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,695.0	1,270,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,695.0	1,270,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,527,250.0	6,405,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,527,250.0	6,405,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	16,081,663.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,081,663.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		16,081,663.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,945,272.0	239,543,765.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,945,272.0	239,543,765.50

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,945,272.0	239,543,765.50
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд 32,840.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг тайлагнаагүй.	1	32,840.2			1	32,840.2	1	32,840.2		
Үнэ төлбөргүй авсан 297,161.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогын зүйлийг буруу тайлагнасан.	1	297,161.9			1	297,161.9	1	297,161.9		
Дүн	2	330,840.2			2	330,840.2	2	330,840.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэмнэгдсэн цалингийн зардлаас үндэслэлгүй, тушаал шийдвэргүй 14 албан хаагчдад 11,013.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	11,013.8	1	11,013.8		
П.Оюунбилэг, Ш.Солонго нарт 5 жилийн мөнгөн урамшуулал олгохдоо 1,608.2 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй	1	1,608.2	1	1,608.2		
2024 оны жилийн эцэст Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангаар татварын	1	8,954.4	1	8,954.4		

байгууллагаас 8,954.4 мянган төгрөгийн авлагатай байна.						
2024 онд тоног төхөөрөмж худалдан авах зардлаас 4,834.6 мянган төгрөгийн шатахуун, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 200.0 мянган төгрөгийн тусламж үзүүлсэн.	1	5,034.6			1	5,034.6
Дүн	4	26,611.0	3	21,576.4	1	5,034.6

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn